



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2022 оны 12 сарын 23 өдөр

Төрийн ордон, Улаанбаатар хот

БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 15 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт доор дурдсан агуулгатай 18 дахь заалт нэмсүгэй:

“18/хүрээлэн байгаа орчны хохирол тооцох аргачлалыг хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнтэй хамтран батлах.”

2 дугаар зүйл. Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 6 дугаар зүйлийн 5 дахь хэсгийн “хохирол учирсныг” гэсний дараа “шүүх шинжилгээний байгууллага, эсхүл” гэж, 49 дүгээр зүйлийн 5 дахь хэсгийн “байгаль орчны” гэсний дараа “болон хууль зүйн” гэж, мөн зүйлийн 6 дахь хэсгийн “хохирлыг” гэсний дараа “шүүх шинжилгээний байгууллагаар, эсхүл” гэж тус тус нэмсүгэй.

3 дугаар зүйл. Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 15 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 18 дахь заалтын дугаарыг “19” гэж өөрчилсүгэй.

4 дүгээр зүйл. Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 15 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 3 дахь заалтын “, хохирол” гэснийг хассугай.

5 дугаар зүйл. Энэ хуулийг Шүүх шинжилгээний тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА

Г.ЗАНДАНШАТАР